



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА НАРТ

**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: (976-11) 323589
E-mail: info@mecss.gov.mn, http://www.mecss.gov.mn

2018. 12. 14 № 4 / 11304
танай _____-ны № _____-г

Тушаал хүргүүлэх тухай

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад хамаарах ажил мэргэжлийн жагсаалт, индекс/кодод Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/179 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулан баталсан.


Ийнхүү шинэчилсэн ажил, мэргэжлийн индекс/кодыг баталснаар төв, орон нутгийн боловсролын сургалтын байгууллагуудын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хийх, ажил, мэргэжлээр ангилсан мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, санхүү, төсвийн тооцооллыг хялбаршуулах, олон улсын харгалзах үзүүлэлттэй харьцуулах зэргээр байгууллагын хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулах үндсэн нөхцөл бүрдсэн.

Тус шинэчилсэн ажил, мэргэжлийн индекс/кодыг хэрэгжүүлэх хүрээнд дор дурдсан ажлуудыг зохион байгуулна уу. Үүнд:

1. Аймаг, нийслэлийн боловсролын сургалтын байгууллагуудын хүний нөөцийн хангамжийн судалгааг ажил, мэргэжлийн жагсаалт, индекс/кодын дагуу гаргах.

2. Дээрх ажил, албан тушаалын жагсаалтын дагуу ажил эрхэлж буй ажиллагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх талаар санал ирүүлэх.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БОЛДОГЫН
ГАЗРЫН ДАРГА Т.НЯМ-ОЧИР



09 19923



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/179

Улаанбаатар хот

Үндэсний ажил, мэргэжлийн ангилал
ба тодорхойлолт 08-д өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт 08-ын 2 дугаар хавсралт "Үндэсний ажил, мэргэжлийн индекс/код"-ын сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад хамаарах 1341, 1345, 2330, 2341, 2342, 2351, 2352, 2359, 2635 нэгж бүлгийн индекс/кодыг хавсралтаар шинэчлэн баталж, 2353-11, 2353-12, 2353-13, 2353-14, 2354-11, 2354-12, 2354-13, 2354-14, 2355-11, 2355-12, 2355-13, 2355-14, 2356-11 индекс кодыг хүчингүй болгосугай.

2. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагуудад энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан салбарын ажил, мэргэжлийн ангилалд дурдсан нэршлийн дагуу байгууллагын ажлын байрны жагсаалт, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, норм норматив тогтооходоо мөрдөхийг зөвлөсүгэй.

САЙД  С.ЧИНЗОРИГ

